

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

---

2010 он 03 дугаар  
сарын 24-ны өдөр

Дугаар 05.

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ: XVIII АСУУДАЛ

“Пенни” хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай тогтоолын төслийг Бичил санхүүгийн газрын дарга Н.Оюунчимэг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Пенни” хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг хэвийн явагдаж байна гэж хуралд оролцсон гишүүд үзэж уг хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай тогтоолын төслийг Санхүүгийн зохицуулах хорооноос томилсон шалгалтын ажлын хэсгээс гарах тайлан, дүгнэлтийг үндэслэн дараагийн хурлаар оруулж шийдвэрлэхээр хойшлуулав.

2. Хорооноос өгсөн үүрэг даалгаварыг чанд биелүүлж ажиллахыг “Пенни” хадгаламж, зээлийн хоршоо / ТУЗ-ийн гишүүн Б.Оргил /-нд үүрэг болгохоор тогтов.

3. Тус хоршоонд газар дээрх шалгалт хийх, Хорооны шийдвэрийн биелэлтэнд хяналт тавин ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т үүрэг болгов.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН